



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 40201

Хархорин сум

Г Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Орхон хороолол 23 тоотод иргэн Ч.Суурьтготохын худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв цогцолборын зориулалтаар эзэмшиж байгаа 6209007034 нэгж талбарын дугаартай 2319м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмигч Ч.Суурьтготох-т газар эзэмших эрхийн эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Ч.Суурьтготох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ОДГЭРЭЛ

401100401